



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 392

Улаанбаатар хот

Г Унэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн  
зөвлөгөө үзүүлэх нэр бүхий хуулийн этгээдийг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Унэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай” 451 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Унэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай журам” батлах тухай 121 дүгээр тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан шинэчлэн бүртгүүлэхээр баримт бичгээ хугацаандаа ирүүлээгүй дараах нэр бүхий хуулийн этгээдийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хассугай.

1. “Вислекс” ХХК;
2. “Контактлегал консалтинг” ХХК;
3. “Лексусконсалтинг групп” ХХК;
4. “Константконсалтинг” ХХК;
5. “Ананд энд батзаяа” ХХК;
6. “Андерсон энд андерсон” ХХК;
7. “Легалвэй” ХХК;
8. “Эдийн засаг эрх зүйн зөвлөгөө” ХХК;

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000442